

ДУЛААН ХАНГАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2025 оны 05 сарын 21-ний өдөр

Дулаан хангамжийн тухай хуульд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл:	Санал: Нэмэх, Өөрчлөх, Хасах	Тайлбар:
2.2. Дулаан хангамж нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. 2.2.1. дулаан хангамж найдвартай байх; 2.2.2. дулаан хангамж аюулгүй байх; 2.2.3. дулаан хангамж үр ашигтай байх; 2.2.4. дулаан хангамж байгаль орчны шаардлагад нийцсэн байх;	Нэмэх: 2.2.5. дулаан хангамжийн тооцоолол шударга байх;	Дулааны эрчим хүч хэрэглэсний төлбөр тооцоог хийхдээ бодит хэрэглээг хэмжиж, тоолуурын заалтыг үндэслэх бус тухайн барилгын талбай, эзлэхүүн зэргийг үндэслэж байгаа учраас хэрэглэгчдийн дулаанаа хэмнэх, ариг гамтай зарцуулах сонирхлыг бууруулж байгаа тул тоолууржуулах шаардлагатай байна. Мөн хэрэглэгчдийг тоолууржуулах ажлыг эхлүүлсэн тохиолдолд хэрэглэгчид дулааны тоолуурыг зөв зохистой ашиглаж байгаа эсэхэд тавих хяналтын механизмыг эрх зүйн хүрээнд зохицуулалт хийх шаардлагатай юм. Дулааны тоолуургүйн улмаас хэрэглэгч, айл өрхүүдээс Орон сууц нийтийн аж, ахуйн удирдах газар, конторууд төлбөрөө м.кв буюу талбайн хэмжээгээр тооцож нэхэмжлэн авч, Улаанбаатар дулааны шугам сүлжээ ОНӨҮГазар төлбөрөө төлөхдөө тоолуурын заалтаа үндэслэн төлбөр төлж байгаа нь конторууд хэрэглэгч, айл өрхүүдийг хамгийн бага дулаан хангамжаар хангаж ашиг орлогоо нэмэгдүүлэх үндэс болж байна. Иймд хэрэглэгчдийг тоолууртай болгох буюу хэрэглээг нь шударгаар тооцоолсноор хэрэглэгчид дулааны нөөцийг хэмнэхэд туслах том хөшүүрэг болох юм. Тиймээс энэ заалтыг нэмэх саналтай байна.